

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 13/380

НШУС

2012

### МОНГОЛЫН СЭТГҮҮЛИЙН ТҮҮХИЙН ҮЕЧЛЭЛИЙН АСУУДАЛД

М. Наранмандах\*

\* СУИС-ийн Радио телевизийн сургуулийн сургалтын албаны дарга, магистр, докторант

**Түлхүүр үг:** хэвлэл мэдээллийн хэрэгслийн систем бүрэлдэн тогтсон нь, Монголын сэтгүүл зүйн түүхийн үечлэл, сэтгүүлийн хөгжлийг түүхэн үүднээс үечлэх нь

**М**онголд анхны тогтмол хэвлэл гарснаас хойш нэгэн зуун өнгөрчээ. 1913 оны 3-р сарын 6-нд "Шинэ толь хэмээх бичиг" сонин анхны дугаар хэвлэгдэн гарснаар үндэсний сэтгүүл зүйн эх үндсийг тавьсан байна. Дэлхийн улс орнуудтай харьцуулахад манай оронд сэтгүүл зүй нэлээд хожуу хөгжсөн ч хэвлэл, мэдээллийн систем бүрэлдэн төлөвшихдөө бусад орны нэгэн адил сонин, сэтгүүлээр эхлэлээ тавьсан байдаг.

Монголын сэтгүүлийн үечлэлийн асуудлыг хөндөхийн тулд Монголд хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүрэлдэн тогтсон онцлог, сэтгүүл зүйн түүхийн үечлэл, нийгмийн хөгжил, сэтгүүлийн мөн чанар зэргийг зайлшгүй дурдах нь зүйтэй юм.

Олон нийтийн мэдээллийн тогтмол хэвлэл (сонин, сэтгүүл), радио, телевиз, мэдээллийн агентлаг, баримтат кино зэрэг үндсэн хэрэгслүүд бүрэлдэн тогтож, мэдээллийн бие даасан салбарын хэмжээнд төлөвшиж, харилцан нөхцөлдсөн нэгдмэл үйл ажиллагаа

явуулах тогтолцоог ОНМХ-ийн систем гэж нэрлэдэг<sup>1</sup>.

"Шинэ толь хэмээх бичиг" сониноос хойш долоон жилийн дараа 1920 оны 11-р сарын 10-нд Эрхүү хотод "Монголын үнэн" анхны дугаараа гаргаснаараа хувьсгалт хэвлэл эх тавьсан, 1921 оны 7-р сарын 19-нд МонТА мэдээллийн агентлаг байгуулагдсан, 1934 онд монголын радио өргөн нэвтрүүлгээ эхлүүлсэн, анхны баримтат кино 1935-1936 онд хийгдсэн, 1941 онд анхны дугаараа уншигчдын гар дээр тавьсан Баян-Өлгий аймгийн "Жана өмир" сониноор орон нутгийн хэвлэл эхэлсэн, 1964 онд гарах болсон Дархан хотын "Найрамдлын Дархан" сонин хотын сонин үндсийг тавьсан, 1967 оны 9-р сарын 27-нд Монгол телевиз өргөн нэвтрүүлгээ цацаж эхэлснээр Монголд ОНМХ-ийн систем бүрэлдэн тогтжээ<sup>2</sup>.

Монголын сэтгүүл зүйн түүхийг эрдэмтэн судлаачид дараах үечлэлд хуваан авч үздэг. Тухайлбал: шинжлэх ухааны доктор Л.Норовсүрэн үндэсний сэтгүүл зүйн түүхийг дор дурдсан үечлэлд хуваажээ:

— *Нэгдүгээр үе:* Монголын үндэсний дэвшилтэт ардчилсан тогтмол хэвлэлийн үе (1913-1920 он)

— *Хоёрдугаар үе:* Монголын хувьсгалт нууц хэвлэлийн үе (1919-1920 он)

— *Гуравдугаар үе*: Монгол улсад социалист нийгэм байгуулахын төлөө тэмцлийн үеийн сэтгүүл зүй (1921-1990 он)

— *Дөрөвдүгээр үе*: Монголын чөлөөт ардчилсан сэтгүүл зүйн үе (1990 оноос хойш)<sup>3</sup>.

Харин доктор Г.Дэлэг Монголын тогтмол хэвлэл түүхийг 1908-1925 он ("Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл", УБ., 1965 он), 1925-1940 он ("Монголын хэвлэл", II боть, УБ., 1972 он), 1940-1971 он ("Монголын хэвлэл", I боть, УБ., 1971 он) гэсэн гурван үед хуваан авч үзэн, үед тус бүрийг дотор нь 3-4 хэсэгт нарийвчлан судалжээ. Тухайлбал, 1908-1925 оны тогтмол хэвлэлийг:

1. Монгол хэл дээр гарсан анхны сонин, сэтгүүл (1908-1919)

2. Монголын дэвшилт ардчилсан сонин, сэтгүүл (1913-1920)

3. Ардын засаг тогтохоос өмнөх Монголын хувьсгалт хэвлэл (1919-1921)

4. Ардын засгийн эхний жилүүдийн Монголын хэвлэл (1921-1925)<sup>4</sup> хэмээн хуваасан байна.

Сэтгүүл, сонины эхлэлийг зэрэг тавьсан "Шинэ толь хэмээх бичиг" 1913 онд уншигчдын гар дээр очсоноос хойш арав шахам жилийн турш хэвлэлийн зах зээл дээр сонин дангаар оршиж байв. Ардын засаг тогтсоноос хойш үеийн Монголын анхны сэтгүүл "Монголын Ардын Нам" МАН-ын II их хурлын шийдвэр ёсоор 1923 оны 10-р сарын 20-ноос товхимол хэлбэрээр сар тутам гарч эхэлжээ. Тус сэтгүүл нь 1930 он хүртэл 6-10 хэвлэлийн хуудас хэмжээтэй, 300-500 хувиар хэвлэгдэж байсан бөгөөд нийт 19 дугаар гарсан байна.

1911 оны 8-р сараас Бээжинд сар тутам гарч эхэлсэн "Монгол ер үгийн

сэтгүүл", 1912 оноос гарч эхэлсэн "Ихэд нийтлэх монгол бичгийн сэтгүүл"-д "сэтгүүл" хэмээх үг анх хэрэглэгдсэн байна. Тогтмол гардаг хэвлэлийн дэвтэрлэсэн бүтээгдэхүүнийг энэ үеийг хүртэл "Бодрол", "Дармал", "Илтгэл" гэх мэтээр нэрлэж иржээ. Тухайлбал: "Монгол үгийн бодрол" (Гирин, 1908), "Монгол үгийн илтгэл" (Нанжин, 1929) зэргийг дурдаж болно. Энэ бүхэн бол зөвхөн "Сэтгүүл" хэмээх хэвлэлийн бүтээгдэхүүнийг нэршүүлэх гэсэн оролдлого байв.

**М**онголын сэтгүүлийн үүсэл хөгжлийг судлахын тулд Г.Дэлэг, Л.Норовсүрэн зэрэг дээрх эрдэмтдийн гаргасан үечлэлийн зэрэгцээ сэтгүүл бие даасан хэрэгсэл болохынх нь хувьд дараах ангиллыг миний бие дэвшүүлж байна. Учир нь сэтгүүл нь мэдээллийн багтаамж, өнгө үзэмж сайтай зэрэг онцлогтойн дээр танин мэдэхүйн ач холбогдол өндөр, удаан хугацаанд хадгалах, эргэж харах боломжтой, харьцангуй шуурхай бус зэрэг шинжээрээ бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээс ялгарах, тэдэнтэй өрсөлдөх чадвартай юм. Үүнд:

**Нэгдүгээр үе буюу сэтгүүлийн үүсч хөгжсөн он жилүүд (1913-1959 он).** Энэ үед хамрагдах сэтгүүлүүд нь улс орны тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдлыг бэхжүүлэх, улс орноо өөрчлөн хөгжүүлэх намын бодлого, зорилтыг сурталчлах, удирдах байгууллагын албан баримт бичиг, тогтоол шийдвэрийг таниулах, үүрэгтэй байв. Түүнчлэн улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралыг тусгасан ухуулга сурталчилгааны материал нийтэлдэг нийт 12 сэтгүүл үйл ажиллагаа явуулж байжээ. Үүнд: 1923-1930 онд хэвлэгдэж байсан "Монголын Ардын Нам", залуучуудын байгууллагын "Манай зам" сэтгүүл (1925-1930 он), 1925 оны 3-р

сарын 19-нөөс гарч эхэлсэн "Бүсгүйчүүдийн санал", 1925-1933 онд хэвлэгдэж байсан "Техникийг эдэлж чадна", 1926-1931 онд хэвлэгдэж байсан "Хозяйство Монголии", 1926 оноос гарч эхэлсэн "Залгамжлагч", "БНМАУ-ын засгийн газрын албаны сэтгүүл" (1926 он), "Улаан цэргийн бодлого" (1927-1931 он), "Бүх Монголын улаан үйлдвэрчин" (1928-1938 он), "Улаан туяа" (1927 оноос), "Багш нарын сэтгүүл" (1930 он), "Хөдөөний ухуулагч" (1931-1932 он) зэрэг сэтгүүлийг дурдаж болно.

1932 оноос эхлэн сэтгүүлийн нийтлэлийн бодлого, төрөлд нэлээд өөрчлөлт орсон байна. Тодруулбал, сэтгүүлүүд зөвхөн намын зорилго зорилт, шийдвэрийг сурталчлан таниулахаас гадна социалист агуулгатай үндэсний соёл урлаг, уран зохиолыг хөгжүүлэх, шинэ нийгэм байгуулах үйлсэд олж байгаа ололт, амжилтыг өргөн мэдээлэх, хууль дүрэм сурталчлах, эрүүл мэндээ сахин хамгаалах, соёлч боловсон байдлыг дээшлүүлэх зорилго чиглэлтэй 20 шахам сэтгүүл хэвлэгдэх болжээ. Тухайлбал: "Хувьсгалын уран зохиол" (1932 он), "Современная Монголия" (1933-1940 он), "Монгол ардын үндэсний соёлын зам" (1934-1940 он), "Хүмүүжил ба жигшил" (1935 оноос), "Шинэ толь" (1935-1940 он), "Цог" (1944 оноос), "Туяа" (1950-1961 он), "Мал аж ахуй" (1950 оноос), "Эдийн засгийн асуудал" (1954 оноос), "Эрүүл

мэнд" (1959 оноос) сэтгүүл хэвлэгдэж байв<sup>5</sup>.

**Хоёрдугаар үе буюу сэтгүүлийн хөгжлийн үе (1960-1990 он).** Энх цагийн их бүтээн байгуулалт, аж үйлдвэрлэл, улс ардын аж ахуйн үндсэн салбарууд, нам, залуучуудын эвлэл, тэргүүн туршлага, шинжлэх ухаан, технологийн ололт, дэвшлийг сурталчлан таниулах, намч, зарчимч байх, намын их хурлуудын шийдвэрийг хэрэгжүүлэх, нийгэмд оршиж байгаа алдаа дутагдал, хүнд суртлыг илчлэх, арилгах үүрэг, зорилготойгоор энэ үеийн сэтгүүлүүд хэвлэгдэж байв. Энэ үед гарсан томоохон өөрчлөлт, гол онцлог нь мэргэжлийн болоод салбар, байгууллагын сэтгүүл олширсон явдал юм. Тухайлбал: 1961 оноос "Оюун түлхүүр",

«

**1932 оноос эхлэн сэтгүүлийн нийтлэлийн бодлого, төрөлд нэлээд өөрчлөлт орсон байна. Тодруулбал, социалист агуулгатай үндэсний соёл урлаг, уран зохиолыг хөгжүүлэх, шинэ нийгэм байгуулах үйлсэд олж байгаа ололт, амжилтыг өргөн мэдээлэх, хууль дүрэм сурталчлах, эрүүл мэндээ сахин хамгаалах, соёлч боловсон байдлыг дээшлүүлэх зорилго чиглэлтэй 20 шахам сэтгүүл хэвлэгдэх болжээ.**

»

1962 оноос "Техник технологийн мэдээ", 1964 оноос "Барилгачин", 1966 оноос "Мэдээлэл", 1981 оноос "Октябрийн туяа", 1972 оноос "Сэтгүүлч", мөн онд "Хүүхдийн хүмүүжил", 1973 оноос "Социалист хууль ёс", 1980 оноос "Анагаах ухаан", 1980 оноос "Жаргалан", 1981 оноос "Пионерийн удирдагч", 1981 оноос "Залуу зохион бүтээгч", 1981 оноос "Санхүү зээл бүртгэл", 1983 оноос "Эдийн засгийн боловсрол"<sup>6</sup> сэтгүүл хэвлэгдэн гарчээ.

**Гуравдугаар үе буюу сэтгүүл эрчимтэй хөгжиж эхэлсэн он жилүүд (1990 оноос хойш).** Нэг намын ноёрхлоос ангижирч, сонин, сэтгүүл,

мэдээллийн агентлаг, радио, телевизийн нийтлэл, нэвтрүүлгийн агуулгыг тусгайлан хянадаг газаргүй болсон нь сэтгүүлийг төдийгүй, хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгслийг хөгжлийн шинэ шатанд гаргасан гэж үзэж болно.

**Х**эрэв 1980-аад онд улсын хэмжээгээр 30 орчим сэтгүүл гарч байсан бол 1990 оны ардчилсан хувьсгалын дараа энэ тоо эрс өсч, 1990 оны 1-р сарын 1-ний байдлаар 124 сэтгүүл улсын бүртгэлд бүртгүүлээд байв. Зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш сэтгүүл нь мэдээллийн хэсэгслийнхээ хувьд адармаатай замыг туулжээ. 2010 оны байдлаар 102 сэтгүүл бүртгэлтэй байсан нь сүүлийн арваад жилийн хамгийн өндөр үзүүлэлт байв.

Сүүлийн жилүүдэд манай орны ОНМХ-ийн систем дотор эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг нь улам нэмэгдэж байгаа хэрэгсэл бол сэтгүүл юм. Сэтгүүлийн ач холбогдол өсөн нэмэгдэж, уншигчдад мэдээлэл өгөх, зугаацуулах, мэдлэг олгох, сэтгэлийн таашаал төрүүлэх зэрэг үүргүүдээ амжилттай гүйцэтгэж байна.

Монголын сэтгүүлүүд нийгмээ даган хувьсан хөгжиж, олон нийтэд нөлөөлөх чадвар нь аажмаар дээшилж байна. 1940-өөд оны үед төр засаг, намын бодлогыг ард түмэнд ухуулах гэх мэт зорилгоор сэтгүүлийг олон мянган хувиар хэвлэн түгээж, нийтлэлийн бодлогыг нь зааж чиглүүлдэг байсан бол өнөө үед ийм зохицуулалт байхгүй болсон нь дэвшилттэй юм. Сэтгүүлийн гаралт, хэвлэх хувь хэмжээг МАХН-ын Төв хорооны Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн хорогдуулах, нэмэгдүүлэх замаар тогтоодог, эсвэл заримынх нь гаралтыг бүрмөсөн зогсоодог байсан бол өнөөдөр тухайн сэтгүүл хэдэн хувь хэвлэгдэх нь зөвхөн зах зээлийн

өрсөлдөөн, нийтлэлийн бодлогын асуудал болсон нь гарцаагүй томоохон дэвшил мөн.

### Ишлэл

- <sup>1</sup> Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 105 дахь тал.
- <sup>2</sup> Зулькафиль М. 2007. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ., 32 дахь тал.
- <sup>3</sup> Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ., 6 дахь тал.
- <sup>4</sup> Дэлэг Г. 1965. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ., 402 дахь тал.
- <sup>5</sup> Дашдорж Ц. 1987. Монголын тогтмол хэвлэлийн товч лавламж. УБ., 26-43 дахь тал.
- <sup>6</sup> Баасансүрэн Т. 2009. 1921 оны Ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн хөгжил. УБ., 198-201 дэх тал

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2009. 1921 оны Ардын хувьсгал ба Монголын хэвлэлийн хөгжил. УБ.
2. Дашдорж Ц. 1987. Монголын тогтмол хэвлэлийн товч лавламж. УБ.
3. Дэлэг Г. 1965. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.
4. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
5. Зулькафиль М. 2007. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.
6. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ.

### Resume

Journalism in Mongolia is developing, accompanying social changes, bringing the influential nature of the people are rising. In the 40's, the government has printed magazines with large circulation to agitate people about policies of the party. Was an attempt to specifically direct the media policy trends. But it is now missing. Stages of development of journalism in Mongolia can be divided into the following steps: First phase - 1923-1960, the second phase - 1960-1990, on the third phase after 1990s.